



2021 ОНЫ ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТЫН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН ЕРӨНХИЙ БЛЮПРИНТ

Шалгалтын нэр	Элсэлтийн ерөнхий шалгалт								
Хугацаа	80 минут								
Даалгаврын тоо	1-р хэсэг сонгох хэлбэрийн 40 тест 80 оноо 2-р хэсэг бүтээлч хэлбэрийн 4 сонгох даалгавар 20 оноо								
Даалгаврын хэлбэр	Сонгох хариулттай асуулт болон бүтээлч хэлбэрийн даалгавар								
Агуулгын харьцаа	№	Үндсэн агуулга	Танин мэдэхүйн түвшин				Нийт		
			Сэргээн санах	Ойлгох	Хэрэглэх	Задлан шинжлэх	Даалгаврын тоо	Эзлэх хувь	
	1	Эх задлал	1	1	2	2	6	13.6	
	2	Өгүүлбэрийн утга, үүрэг, хэрэглээ	1	2	2	2	7	15.9	
	3	Үгийн утга, үүрэг, хэрэглээ	1	1	1	2	5	11.4	
	4	Бүтээврийн утга, үүрэг, хэрэглээ	2	1	1	1	5	11.4	
	5	Зөв бичих дүрэм	-	2	2	-	4	9.1	
	6	Уран зохиол	1	2	2	1	6	13.6	
	7	Монгол бичиг	2	4	4	1	11	25.0	
	Нийт даалгаврын тоо			8	13	14	9	44	100
	Эзлэх хувь			18.2	29.5	31.8	20.5		

2021 ОНЫ ЭЕШ-ЫН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН СЭДЭВ ДААЛГАВРЫН АГУУЛГЫН ХҮРЭЭ

№	АГУУЛГА	ДЭД АГУУЛГА	АНГИ
1	Эх задлал	Эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог тодорхойлох	VI-XII
		Эхийн сэдэв, гол санааг тодорхойлох	VI-XII
		Уран дүрслэл, хэлц, нэр томъёо, мэргэжлийн үг хэллэгийг хэрэглэсэн зорилгыг тодруулж, утга, үүргийг тайлбарлах	VI-XII
		Орон, цаг, зорилго, шалтгааны утгыг эхийн жишээгээр харьцуулан, тайлбарлах	VI-XI
		Үйл явдлыг хүүрнэн бичихдээ орон цаг, нөхцөл байдлыг дүрслэн, мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлэх	VI-XI
		Эхийг хурааж, дэлгэрүүлж найруулан бичих	VI-XI
		Зохиогчийн ашигласан баримт мэдээлэлд дүн шинжилгээ хийх	VI-X
		Эхэд зохиогчийн үг сонгосон шалтгааныг тайлбарлах	VI-X
		Эхэд үг хэллэг хэрэглэсэн зорилгыг тайлбарлах	VI-X
		Загварт найруулгын бүтэц онцлог, агуулгын уялдаа холбоог гаргах	VII-X
		Бичгийн найруулгын зэргийг ялгах	X
		Баталсан, таамагласан, үгүйсгэсэн утгат баймж нэгжүүд, угсруулан ба зэрэгцүүлэн холбох үг, нөхцөл болон орон, цаг, шалтгааны утгат угсруулан холбох бүтээврээр зохиогчийн хэлний онцлогийг тайлбарлах, тодорхойлох	IX
		Баримтад үндэслэн тайлбарлан бичих	IX
		Албан бичгийн найруулгын онцлогийг тодорхойлох	VII-XI
		Найруулгын хэв маягийг таних	VII-IX
		Найруулгын алдааг олох, засах	VI-XI
		Эхийн хувиргал	VI-XI
		Эхэд тооны нэр, тэмдэг нэр, дуурайх үгийг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын утга, үүргийг тодорхойлох	VII
		Тооны нэр, баримт нотолгоо, жишээ ашиглан танилцуулга, илтгэх хуудсыг тоочин бичих	VII
		Уншсан эхийн орон ба цагийн дүрслэлээр үйл явдлын орчныг тодорхойлох	VI
Уншсан эхийн доторх харилцан ярианы үүргийг тодорхойлох	VI		
Уншсан эхээс чухал хэсгийг олж, бичигчийн санааг тайлбарлах	VI		

2	Өгүүлбэрийн утга, үүрэг, хэрэглээ	Өгүүлбэрийн бүтэц, утга, ангилал, хувиргал	VI-XI
		Холбох хэрэглүүрээс сонгож, нийлмэл өгүүлбэрийг хувирган найруулах	VII-XI
		Холбох хэрэглүүрийн утга, үүргийг тодорхойлж, нийлмэл өгүүлбэрт сонгон найруулах	VII-XI
		Нийлмэл өгүүлбэрийн утга, бүтэц, хэрэглээг таньж, эхэд гүйцэтгэх үүргийг тайлбарлах	VII-XI
		Өгүүлбэрийн гишүүдийн хэлбэржилт утга байрыг тодорхойлох, эхийн найруулгад гүйцэтгэх үүргийг тодорхойлох	VI-X
		Зэрэгцүүлэн, угсруулан холбох бүтээвэр, үгийн утгыг ялган таних тайлбарлах	VI-X
		Бичгийн найруулгын зэргийг ялгах	X
		Шалтгааны утгатай УНӨ-ийн бүтсэн аргыг тодорхойлох	VIII
		Нутгийн аялгууны үг, гадаад үг хэллэгийн найруулгын үүргийг тодорхойлох	VIII
		Угсарсан нийлмэл үгийг ялган таньж, эх өгүүлбэрт гүйцэтгэсэн найруулгын үүргийг тодорхойлох	VIII
		Найруулгын алдааг олох, засах	VI-XI
		Хэлэх аялга, зэрэгцүүлэн холбох үг, нөхцөл нь зэрэгцүүлэн холбоход чухал үүрэгтэй байгааг эхийн жишээгээр тодруулан, зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн найруулгын үүргийг тайлбарлах	VII
		Товч мэдээллийг холбоотой баримтаар дэлгэрүүлэх	VI
3	Үгийн утга, үүрэг, хэрэглээ	Өөрийн болон бусдын зохиосон эхийн найруулгыг судалж, үг илүүдсэн, давтсан зэрэг алдааг таньж, сайжруулах	VI
		Үгийн аймгийн тухай ойлголт, ангилал	VI-VIII
		Холбоо үг, түүний ангилал, хэрэглээ	
		Өвөрмөц, хэвшмэл хэлцийг тухайн найруулгад сонгон хэрэглэх	VII-XI
		Үгийн бүтцийг задлан ялгаж, бүтээврийн нийлцийг зөв бичих	VII
		Уншсан эхэд жинхэнэ нэр, нэрийн тийн ялгал, биед ба эзэнд хамаатуулах нөхцөл, олон тооны дагаврыг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлох	VI
		Уншсан эхэд орон цагийн нэрийг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлох	VI
Үгийн бүтцийг задлан ялгаж бүтээврийн нийлцийг зөв бичих	VI		

4	Бүтээврийн утга, үүрэг, хэрэглээ	Орон цаг, зорилго, шалтгааны утгатай бүтээвэр, холбох үг, өгүүлбэрийн утгыг тодорхойлох, сонгох	VII-XI
		Ойролцоо, эсрэг утгатай бүтээвэр, үг өгүүлбэрийн утгыг ойлгох хэрэглэх	VI-X
		Уншсан эхэд үйлийн цагаар төгсгөх болон биеэр төгсгөх, тодотгон холбох болон нөхцөлдүүлэн холбох нөхцөлийг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлох	VI
5	Зөв бичих дүрэм	Монгол үсгийн тухай дүрэм	VI-VII
		Гээгдэх эгшгийн дүрэм	VI-VII
		Балархай эгшгийн дүрэм	VI-VII
		Хатуу, зөөлний тэмдгийн дүрэм	VI-VII
		Үеийн тухай, үг шилжүүлэх дүрэм	VI-VII
		Утгат хэсгийг зөв бичих бүрэм	VI-VII
		Цэг цэглэлийг хэрэглэх	IX
6	Уран зохиол	Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлах.	VI-XII
		Зохиолын өгүүлэгдэхүүн ба зохиомжийн нэгжүүдийн уялдаа холбоог таньж, утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох	VI-XII
		Зохиолын гадаад ба дотоод орчныг задлан шинжилж, дүр ба сэдвийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох	VII-XI
		Яруу найргийн хэлбэр, бүтцийг шинжлэх	VII-XI
		Зохиолын хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг задлан шинжлэх	VII-XI
		Зохиолын утга бүтцийн онцлогийг задлан шинжилж бичихдээ холбогдох нэр томъёог хэрэглэх	VII-XI
		Зохиолын өгүүлэгдэхүүн бүтэц, хүүрнэлийн холбоо хамаарлыг тайлбарлах	VI-X
		Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох	VI-X
		Яруу найргийн айзам, эгшиглэл, бадаглалыг тайлбарлах	VI-X
		Шүлэглэсэн зохиолын шад, холбоц, бадаглалын туршлагыг шинжлэх	IX
		Зохиолын утга санааг бүрдүүлэхийн тулд сэдэв, хам сэдвийг хэрхэн хөгжүүлснийг дүгнэх	VII-IX
		Зохиолын орчин, нөхцөл байдал нь сэдэв утгыг тодруулахад нөлөөлж буйг шинжлэх	VII-IX
		Зохиолын орчин, нөхцөл байдал нь зохиолын сэдэв, утгыг тодруулахад нөлөөлж байгааг тайлбарлах	VII
Зохиолын дүрийн шууд ба шууд бус тодорхойлолт (үг, үйлдэл, бодол санаа)-оос дүрийн зан төрхийг тодорхойлж, үнэлэх	VII		

		Зохиолын дүрийн үг үйлдлээр зан төрхийг харуулж, дүрд тоглох	VII
		Зохиолын өгүүлэгдэхүүний үйл явдлын эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайллаар ялган таних	VI
		Зохиолын орчныг орон ба цагийн дүрслэлээр ялган таньдаг.	VI
		Зохиолын дүрийн үг, үйлдлээс зорилгыг тодорхойлох	VI
7	Монгол бичиг	Эхийг унших	VI-XII
		Хүндэтгэлийн үг хэллэгийн утгыг тайлбарлан бичих	VIII-XI
		Шинжлэх ухаан танин мэдэхүйн эхийг уншиж ойлгох	VIII-XI
		Мэндлэх, хүндлэх, талархах, эерүүлэх, цээрлэх, бэлгэдэх үг хэллэгийг бичих	X-XI
		Өргөн хэрэглээний өвөрмөц бичлэгтэй үгийг бичих	VIII-XI
		Идэвхтэй хэрэглээ бүхий үгийн үндэс залгаврыг зөв бичих	VIII-XI
		Дармал, бичмэл, хорголжин бар, хулсан үзгийн тигээр бичсэн эхийг уншиж ойлгох, дүгнэлт хийх	X
		Зохиолын үгийн сангийн онцлог шинжийг харьцуулах	IX-X
		зохиолын үг хэллэгийг түүвэрлэн ялгаж, утгыг тайлбарлах	X
		Сонгодог бичгийн зохиол бүтээлийг кириллээс монгол бичигт, галигаас монгол бичигт алдаагүй бичих	VI-X
		Орчин үеийн зохиол бүтээлээс алдаагүй, цэвэр сайхан бичих	VI-X
		Сурах бичгийн хүрээний идэвхтэй хэрэглээ бүхий үгийн үндэс, залгаврыг холбох эгшгийн дүрмээр зөв бичих	VI-X
		Зохиолын үгийн сангийн онцлог шинжийг харьцуулах, задлан шинжлэх, тайлбарлах	VI-X
		Сурах бичгийн хүрээний түүхэн, хуучирсан үг хэллэгийг таних, утгыг тольчлон тайлбарлах	X
		Дармал, бичмэл, бийрээр бичсэн эхийг хурдан, шударга уншиж ойлгох	VII-IX
		Сурах бичгийн хүрээн дэх дуудлага бичлэг зөрүүтэй үгсийг толь бичиг ашиглан зөв бичих	VII-IX
		Нэр, үйл үг бүтээх хувилгагч дагаврыг холбох ёсны дагуу зөв залган бичих	VII-IX
		Нэр, үйл язгуур, үндсийг харьцуулах аргаар ялган таних	VIII
		Хувилгагч, эс хувилгагч залгаврын бүтэц, хэлбэрийг харьцуулан судалж, холбох ёсны дагуу зөв хувилган бичих	VIII
		Үйл үгийн хэв, байдлын дагавар, холбох, төгсгөх нөхцөлийг зөв бичих	VIII
Урт, хос эгшигтэй үгийг зөв бичих	VII		
Үйл үгийн язгуур үндсийг цагаар төгсгөх нөхцөлөөр зөв ялган бичих	VII		

	Урт, хос эгшгийг тэмдэглэх ёсыг таних	VII
	Холбох эгшгийн дүрмийг таньж, цагаар төгсгөх нөхцөлөөр хувилган бичих	VII
	Холбох эгшгийн дүрмийг таньж үйл үгийг зөв хувилган бичих	VII
	Үндэсний бичгийн үндсэн зурлагыг харьцуулах аргаар ялган таних, хичээнгүй бичих	VI
	Нэр үгийг олон тооны дагавар, тийн ялгал, хамаатуулах нөхцөлөөр зөв хувилган бичих	VI

2021 оны ЭЕШ-ын Монгол хэл хичээлийн сэдэв, даалгаврыг суурь, бүрэн дунд боловсролын сайжруулсан сургалтын хөтөлбөрийн заавал судлах агуулга дахь танхимаар судалсан агуулгын хүрээг хамруулан тодорхойлж гаргасан. Гэхдээ хүснэгтэд заагдсан агуулга нь тухайн шалгалтын даалгаврын тооноос хамаарч бүрэн хамрах албагүйг анхаарах хэрэгтэй.

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ